



1. **Байршил** Сүхбаатар дүүрэг 9-р хороо орон сууцны VII-р хороолол
2. **Ажлын цар хүрээ:** “СБД, Цагаан байрны зүүн талын автобусны буудлыг шилжүүлж, орц, гарц гаргах” НН1008АОСТ/202009004

3. Тавигдах ерөнхий шаардлага:

Сүхбаатар дүүргийн 9-р хороонд баригдах орон сууцны хорооллын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу цагаан байрны зүүн талын автобусны буудлыг шилжүүлж, орц, гарц гаргах ажлыг өгөгдсөн ажлын зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.

Уг ажлыг гүйцэтгэхэд: **MNS 5879:2012** Автобусны буудлын зогсоол стандартыг мөрдлөг болгон ажиллана.

Өгөгдсөн ажлын тоо хэмжээг жишиг болгон ашиглах бөгөөд ажлын зураг төслийн дагуу өртгийг тодорхойлно. Үүнд:

ГАЗАР ШОРООНЫ АЖИЛ

- | | |
|---|------------------------|
| 1. Зөөврөөр далан байгуулах | - 121м ³ |
| 2. Ухмалыг ухаж, зайлуулах | - 219.36м ³ |
| 3. Авто замын хуучин хашлагыг ухаж зайлуулах | - 93у/м |
| 4. Явган хүний хуучин хашлагыг зайлуулах | - 92.5у/м |
| 5. Явган хүний замын хуучин хавтанг зайлуулах | - 216м ² |
| 6. Зогсоолын хучлагыг хийн алхаар эвдэж, хуулж ачих | - 37.00м ² |

ЗОГСООЛ БАЙГУУЛАХ АЖИЛ

- | | |
|---|------------------------|
| 7. Замын хашлага тавих /1*0.3*0.18м/ | - 123.5у/м |
| 8. Цементээр бэхжүүлсэн суурь байгуулах h=10см | - 210.5м ² |
| 9. Шингэн түрхлэг хийх | - 544м ² |
| 10. Халуун асфальтбетон хольцоор суурь хучилт байгуулах h=5см | - 10.525м ³ |
| 11. Халуун асфальтбетон хольцоор өнгө хучилт байгуулах h=10см | - 16.675м ³ |
| 12. Явган хүний замын хашлага тавих h=6см | - 91у/м |
| 13. Явган хүний замын суурийг элс-хайрганы хольцоор хийх | - 24м ³ |
| 14. Явган хүний замын хучилтийг өнгөт хавтангаар хийх | - 240м ² |
| 15. Худаг засварлах | - 2ш |

16. Тролейбусны шон шилжүүлэх	- 2ш
17. Замын тэмдэг суурилуулах	- 3ш
18. Замын тэмдэглэгээг зориулалтын машинаар хийх	- 188.5у/м
19. Хөлдөлтөөс хамгаалах үе байгуулах h=30см	- 36.9м3
20. Буталсан чулуун хольцыг автогрейдерээр тэгшлэж суурь байгуулах h=20см	- 24.6м3
21. Автобусны зогсоол, хилийн эгнээний тэмдэглэгээ хийх	- 80.5у/м
22. Явган гарцын тэмдэглэгээ хийх	- 8.4м2
23. Чиг заагч сум	- 2.4м2

Дээрх ажлуудыг норм ба дүрэм, стандартын дагуу чанартай хийж гүйцэтгэх.

Зураг төсвийн үнэ 3.0 /гурван сая/ төгрөгийг төсөвт тооцож оруулах.

Өртгийг тодорхойлохдоо 2020 оны байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа норм, норматив, жишиг тарифийг мөрдсөн байна. Ажил гүйцэтгэхтэй холбогдсон бүх зардлыг /техник хяналтын зардал, магадалшгүй ажил, татвар хураамж, нүүлгэн шилжүүлэх гэх мэт/ үнийн саналд хамруулсан байна. Хэрэв тооцоогүй тохиолдолд захиалагч хариуцахгүй.

Хэрэглэх материалууд нь шинэ, ашиглагдаагүй, эрүүл ахуйн болон ашиглалтын чанарын шаардлага хангасан байхаар сонгоно.

Материал сонголт ажил гүйцэтгэх явцад захиалагчтай зөвшилцөнө.

Ажлыг гүйцэтгэж байх явцад технологийн үе шат бүрд гүйцэтгэсэн ажлыг төслийн захиалагч болон зохиогчийн /техникийн/ хяналт хийлгэж үзүүлж байх ба техникийн шаардлага хангасан гэж үзвэл зөвшөөрлийг авч ил далд ажлын акт, гүйцэтгэлийн зураг үйлдсэнээр дараагийн үе шатны ажлыг гүйцэтгэнэ.

4. Барилгын ажлын зохион байгуулалт, түүнд тавигдах шаардлагууд.

Ажил гүйцэтгэх явцад зам дээр ажиллаж буй ажилчдын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны нөхцөлийг гүйцэтгэгчийн зүгээс хангаж ажиллана.

Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөж буй хууль, тогтоомж, БНБД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.


Автобусны буудлын ажлыг хийж гүйцэтгэхдээ гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу хугацаанд нь ашиглалтад өгөхөөр ажлын талбайн зохион байгуулалтыг хийх шаардлагатай.

Угсралтын ажлын явцад техникийн шийдэлтэй уялдан гарах асуудлыг газар дээр нь захиалагч болон бусад холбогдох хүмүүстэй хамтарч шийдэл гаргаж хэрэгжүүлнэ.

Талбайд барилгын ажлын журналыг байнга бэлэн байлгаж, холбогдох хяналтын инженерүүдийн өгсөн шаардлага, дүгнэлтийг журналд бичиж хөтлөн захиалагчаар баталгаажуулан хэрэгжүүлнэ.

Үйлдвэрлэлийн технологийн үйл ажиллагаа, зохион байгуулалтын төлөвлөлтийг боловсруулж ажиллана.

ХЯНАСАН: "НОГООН НУУР 1008"
АЙЛЫН ОРОН СУУЦ ТХН-ИЙН ЗОХИЦУУЛАГЧИЙН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ:



Д.ОД

БОЛОВСРУУЛСАН: "НОГООН НУУР 1008"
АЙЛЫН ОРОН СУУЦ ТХН-ИЙН
ТАЛБАЙН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР



С.ЖАМБАЛНАВАГ